ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2022 оны 12 сарын 30 өдөр Дугаар А/100 Улаанбаатар хот

Шинэ жилийн баяр, амралтын өдрүүдэд
тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангах
зарим арга хэмжээний тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2, 20.2.8 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2.1 дэх заалт, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/611, 2020 оны А/36 дугаар тушаал, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 5/5870 тоот албан тоотыг тус тус үндэслэн Шинэ жилийн баярын үеэр эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангах зорилгоор ТУШААХ нь:

1. Шинэ жилийн баярын болон амралтын өдрөөр буюу 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 18.00 цагаас 2023 оны 1 дүгээр сарын 02-ны өдрийн 06.00 цаг хүртэл эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангаж, төвийн нийт эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтнууд гар утсаа нээлттэй байлгахыг үүрэг болгосугай.

2. Шинэ жилийн баярын өдрөөр хариуцлагатай жижүүр, дуудлагаар ажиллах ажиллагсдын хуваарийг хавсралтаар тус тус баталсугай.

3. ЦССҮТ-ийн тохиолдлын удирдлагын тогтолцооны хариу арга хэмжээний төлөвлөгөө, хаягийн бүртгэлд дахин тодотгол хийхийг Төлөвлөлт, хяналтын багийн ахлагч /Ч.Батболд/-д, нийтээр амрах баярын болон хөл хорионы өдрүүдтэй холбогдуулан цус, цусан бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлж, шаардлагатай үед ажиллах ажиллагсдын бэлтгэлийг хангуулахыг Сувилахуй, үйлчилгээний албаны дарга /Ж.Нармандах/, Донор зохион байгуулалтын тасгийн эрхлэгч /Ч.Тунгалаг/, Үйлдвэрлэлийн тасгийн эрхлэгч /Н.Халиун/, Нэгдсэн лабораторийн тасгийн эрхлэгч /М.Цэрэндэжид/ нарт тус тус үүрэг болгосугай.

005111

4. Шаардлагатай үед дуудах донорын карт, цус цуглуулах, шинжилгээ хийх, цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд шаардлагатай оношлуур, хүүдий, багаж хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, ариутгал, халдваргүйтгэлийн бодис, хоол, хүнсний нөөцийг бэлтгэж, хүлээлцэхийг Сувилахуй, үйлчилгээний албаны дарга /Ж.Нармандах/, Донор зохион байгуулалтын тасгийн эрхлэгч /Ч.Тунгалаг/, Үйлдвэрлэлийн тасгийн эрхлэгч /Н.Халиун/, Нэгдсэн лабораторийн тасгийн эрхлэгч /М.Цэрэндэжид/, Санхүү, бүртгэлийн албаны дарга /Х.Одгэрэл/, мөн албаны нярав /Д.Буриад/ нарт, техникийн саатал гарсан үед ажиллуулах нөөц цахилгаан үүсгүүр, цахим сүлжээний системийн үйл ажиллагааг шалгаж бэлэн байдлыг ханган ажиллахыг Инженер техникийн тасгийн дарга /Б.Додьгалсан/, Мэдээллийн технологийн инженер /Ч.Далайцэрэн, Х.Гунгаанаран/ нарт тус тус даалгасугай.

5. Төвийн 1, 2 дугаар байрны галын болон шугам, сүлжээний аюулгүй байдлыг шалгаж, гал, усны эрсдэлээс сэргийлэхийг гэрээт харуул, хамгаалалтын албанд анхааруулж, ажлын байрыг орхихгүй байх сэрэмжлүүлэг өгч, хяналт тавьж ажиллахыг Захиргаа, маркетингийн албаны дарга /Ч.Батболд/, болзошгүй гамшиг, осол, хордлого, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед ажиллах төлөвлөгөөг мөрдөн, эмнэлгийн яаралтай тусламж, хүний нөөц, багаж тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж ажиллахыг Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн мэргэжлийн ангийн нарийн бичгийн дарга /Ч.Далайцэрэн/, Цусны чанар, аюулгүй байдлын албаны дарга /А.Амарзаяа/ нарт тус тус үүрэг болгосугай.

6. Хариуцлагатай жижүүр, эмч, жижүүрийн сувилагч нарт даалгах нь:

5.1. Хариуцлагатай жижүүр, жижүүрийн сувилагч нар цус, цусан бүтээгдэхүүний нөөц, үйлчилгээний явцын талаар өдөр бүр 09.00-12.00 цагийн хооронд төвийн Ерөнхий захиралд болон ЭМЯ-ны хариуцлагатай жижүүрт 323002 дугаарын утсаар, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 70128801 утсаар тус тус мэдээлэл өгөх /ЭМС-ын 2019 оны А/611 дүгээр тушаалаар батлагдсан маягтын дагуу/;

5.2. Нийтээр тэмдэглэх баярын өдөр хариуцлагатай жижүүр, жижүүрийн сувилагч нар Төвийн дотоод журам, эмнэлэгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг чанд сахин хариуцлагатай, сонор сэрэмжтэй ажиллаж, ямар ч тохиолдолд холбоо барих боломжтой байх /гар утсаа унтраахгүй нээлттэй байлгах/;

5.3. Төвийн барилгын галын аюулгүй байдлыг шалгаж, галын эрсдэлээс сэргийлэх, төвийн 2 дугаар байрны харуултай хоногт 3 удаа холбогдож, бүтээгдэхүүн хадгалж байгаа хөргөгч, хөлдөөгчийн хэмийн хяналтыг асууж, жижүүрийн сувилагчийн дэвтэрт тэмдэглэх;

5.4. Хариуцлагатай жижүүрийн дэвтэрт үүрэг гүйцэтгэлтийн талаар тэмдэглэл хөтлөх, шаардлагатай үед утсаар ярьсан тохиолдол бүрийг тэмдэглэх;

5.5. Шаардлагатай үед дуудах донорын карт, цус цуглуулах, шинжилгээ хийх, цус, цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэхэд шаардлагатай оношлуур хүүдий, багаж хэрэгслийг бэлэн байдал, хүлээлцэлтийн байдалд хяналт тавих;

5.6. Цахилгааны нөөц үүсгүүрийг ажиллуулах инженерийг шаардлагатай үед хуваарийн дагуу дуудаж бэлэн байдлыг хангах.

6. Эрүүл мэндийн сайдын Эрүүл мэндийн яамын Эмнэлгийн тусламжийн үйлчилгээний газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 5/5870 тоот албан тоотоор өгсөн чиглэл, энэ тушаалыг нийт ажилтнуудад танилцуулан, баталгаажуулж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, маркетингийн албаны дарга /Ч.Батболд/-д даалгасугай.

Хавсралт .... хуудастай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ Н.ЭРДЭНЭБАЯР

1118266548 9128905

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын
2022 оны ..12.. сарын ..30..-ний
өдрийн ..А/100.. тушаалын
хавсралт

## ХАРИУЦЛАГАТАЙ ЖИЖҮҮР, ДУУДЛАГААР АЖИЛЛАХ АЖИЛЛАГСДЫН ХУВААРЬ

| № | Алба, тасгийн нэр | Утасны дугаар | Өдрүүд | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 12.30 | 12.31 | 1.01 | 1.02 |
| Нэг. Дуудагдан ажиллах ажиллагсдын хуваарь | | | | | | |
| 1.Сувилахуй, үйлчилгээний алба | | | | | | |
| 1 | Д.Болормаа | 8872-9072 | + | | | |
| 2 | Ц.Өлзийхишиг | 8950-2326 | | + | | |
| 3 | Ц.Отгон | 9511-3227 | | | + | |
| 4 | Н.Идэржавхлан | 8863-8104 | | | | + |
| 2.Донор зохион байгуулалтын тасаг | | | | | | |
| 1 | Ч.Тунгалаг | 9904-0333 | + | + | | |
| 2 | Д.Сарантуяа | 9982-9960 | | | + | + |
| 3. Нэгдсэн лабораторийн тасаг | | | | | | |
| 1 | Н.Баяртогтох | 9917-8185 | + | + | | |
| 2 | Б.Анударь | 8004-6954 | | | + | + |
| 4. Үйлдвэрлэлийн тасаг | | | | | | |
| 1 | П.Цэндхүү | 9986-8300 | + | + | | |
| 2 | Б.Танхилмаа | 9016-1661 | | | + | + |
| 5. Инженер, техникийн тасаг | | | | | | |
| 1 | Д.Хаянхярваа | 8957-8011 | + | | | |
| 2 | Н.Даваанням | 8971-9998 | | + | | |
| 3 | Б.Додьгалсан | 8900-9884 | | | + | |
| 4 | Ж.Эрхэмбаяр | 8089-7395 | | | | + |
| 6. Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн алба | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Х.Гунгаанаран | 8597-7198 | + | + | + | + |
| 8.Санхүү, бүртгэлийн алба | | | | | | |
| 1 | Б.Алтанзул | 9909-2467 | + | + | | |
| 2 | Б.Буриад | 9903-3548 | | | + | + |
| 9. Цусны чанар, аюулгүй байдлын алба | | | | | | |
| 1 | Э.Чагцалдулам | 8809-8312 | + | + | + | + |
| Хоёр. Хариуцлагатай жижүүрийн хуваарь | | | | | | |
| 1 | Х.Одгэрэл | 9976-6277 | Ж | | | |
| 2 | Ж.Нармандах | 8804-0689 | | Ж | | |
| 3 | А.Амарзаяа | 9992-2960 | | | Ж | |
| 4 | Ч.Батболд | 9907-2449 | | | | Ж |

+ - дуудагдах ажилтан

Ж- Хариуцлагатай жижүүр